

## **БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 06 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

### **Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар:**

#### **Төрийн захиргааны чиглэлээр:**

Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулж, нэгжийн удирдах 2, дэс түшмэлийн ангиллын 14, туслах түшмэлийн ангиллын 5 албан тушаал нөхөгдсөн.

Улс орны хэмжээнд онцгой нөхцөл байдал үүсэж, Монгол Улсын Засгийн Газрын шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төрийн албаны үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэж буй байдалтай танилцах, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, шинэтгэлийн үед хийгдэж буй үйл ажиллагааг таниулах, санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр зохион байгууллаа. Тус ажлын хэсэг орон нутгийн удирдлагуудтай уулзаж, өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллаж байгаа төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, зөвлөгөө мэдээллээр хангалаа. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн болон Булган аймгийн 16 сум 1 тосгоны, Засаг даргын Тамгын газрын дарга нартай цахим уулзалт хийж, санал хүсэлтийг сонсож, зөвлөгөө өгөв. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар төрийн байгууллагуудад хяналт шалгалт хийж, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн 70 зорилтын 379 арга хэмжээний хэрэгжилтэд 2017-2020 оны өссөн дүнгээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна.

Аймгийн 16 сум, 1 тосгон, төрийн байгууллагын 2020 оны эхний хагас жилийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж ажиллалаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2020 оны эхний хагас жилд 65 тогтоолын 125 заалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 65 зорилтын 101 арга хэмжээг манай аймагт даалгасныг хяналтад авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 10-ны дотор хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулж, цаасаар ЗГХЭГ-т хүргүүлнэ. Мөн аймгийн ИТХ, ИТХТ-ийн тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ИТХТ-ийн хуралд танилцуулахаар ажиллаж байна.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Аймгийн төрийн сангаар үйлчлүүлэгч төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог хийж гүйцэтгэн 1961 ширхэг төлбөрийн хүсэлтээр 6.1 тэрбум төгрөгийн гүйлгээг дамжуулсан байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Гурванбулаг сумын соёлын төвийн барилгын засварын ажилд 30.0 сая, Бугат сумын цэцэрлэгийн барилгын засварын ажилд 50.0 сая, Баян-Агт сумын дотуур байрны барилгын засварын ажилд 30.0 сая, Булган

сумын 1-р сургуулийн биеийн тамирын талбайн тохижилтын ажилд 20.0 сая төгрөг, Орхон сумын спорт заалны барилгын ажилд 10.0 сая, нийт 120 сая төгрөг, аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй Сэлэнгэ сумын цэцэрлэгийн өртгөтгөлийн барилгын дуусгалын ажлын зохиогчийн хяналтын зардалд 3.0 сая, Баян-Агт сумын сургуулийн дотуур байрны барилгын засварын ажилд 15.0 сая, Хишиг-Өндөр сумын шинэ суурьшлын бүсэд цахилгаан хангамж татах ажилд 15.0 сая, Булган сумын 1-р сургуулийн биеийн тамирын талбайн тохижилтын ажилд 38.0 сая, аймгийн хөгжимт жүжгийн театрын зураг төслийн ажилд 10.0 сая, Орхон сумын сургуулийн спорт заалны барилгын ажилд 10.0 сая, Гурванбулаг сумын соёлын төвийн барилгын засварын ажилд 20.0 сая, Бугат сумын цэцэрлэгийн барилгын их засварын ажилд 25.0 сая, Хишиг-Өндөр сумын шинэ суурьшлын бүсэд цахилгаан хангамж татах ажилд 25.0 сая, Сайхан сумын ЭМТ-ийн уламжлалт, нөхөн сэргээх эмчилгээний тоног төхөөрөмжийн ажилд 14.9 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй Булган сумын Ахмадын өргөөний барилгын ажилд 241.4 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг тус тус нээсэн.

Аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Зоон давааны навчит модны зурвас байгуулах ажилд 7.7 сая, Ойн хортны тэмцлийн ажилд хяналт хийсэн томилолтын зардалд 954.0 мянга, байгаль хамгаалагч морин эргүүл ажиллуулсан зардал Хангал суманд 480.0 мянга, Сэлэнгэ суманд 1080.0 мянга, Төлүүгийн даваа, Дондогийн булагт авто зам дагуу хогийн сав байршуулах ажилд 2.0 сая, Булган сумын ногоон байгууламжийн ажилд 14.0 сая, Тусгай хамгаалалттай газар нутагт биотехникийн арга хэмжээ авах ажилд 10.0 сая, Сайхан сумын инженерийн шугам сүлжээний ажилд 84.8 сая, Ойн хортны тэмцлийн ажилд 49.6 сая, Ойжуулалтын ажилд 17.0 сая, Сайхан сумын инженерийн шугам сүлжээний 2 дахь шатны ажилд 145.6 сая, Рашаант сумын хог хаягдлын цэгийг дарж булах ажилд 9.8 сая, Шинэ хөдөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд 7.0 сая, Аймгийн ЗДТГ-т лед дэлгэц нийлүүлэх ажилд 15.0 сая, Булган сумын дулааны шугам сүлжээний өөрчлөлт, шинэчлэлтийн ажлын зураг төсвийн зардалд 40.6 сая, Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажилд дэмжлэг 2.0 сая, Сумдын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан боловсруулах ажилд 16.0 сая, Ойжуулалтын хяналтын зардалд 0.8 сая, Булган аймгийн газар нутгийг илэрхийлсэн самбар хийж, хил орчмын бүсүүдэд байршуулах ажилд 25.6 сая, Ойжуулалтын ажилд 26.1 сая, Булаг шандны эхийг хашиж хамгаалах ажилд 26.7 сая, Тэшиг сумын Хужирт багт сэргээгдэх эрчим хүсний эх үүсвэрээр хангах ажилд 34.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Нээлттэй дуудлага худалдаагаар Хялганат тосгоны захирагчийн ажлын албаны Кама маркийн хогны машиныг 711.1 мянга, Баяннуур сумын ЗДТГ-ын Кама маркын хогийн машиныг 800.0 мянга, Баяннуур сумын ЗДТГ-ын УАЗ фермер маркын автомашиныг 1200.0 мянган төгрөгөөр тус тус худалдсан байна.

Хязгаартай дуудлага худалдаагаар Булган Мээж ХХК-ийн Кама маркийн хогийн машиныг 500.0 мянга, Булган сумын Соёлын ордны УАЗ 22069-033 маркын автомашиныг 1500.0 мянган төгрөгөөр тус тус худалдсан байна.

Биеийн тамир, спортын газрын УАЗ 22069-033 маркийн автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдахаар [bulgan.gov.mn](http://bulgan.gov.mn) сайт болон мэдээллийн самбарт байршууллаа.

Санхүү, хяналт аудитын алба Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Ойн анги, Номын сан, Музейд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж байна.

Аймгийн татварын хэлтэс нь Улсын төсөвт дүнгээр 341.2 сая, аймгийн төсөвт 9192.3 сая, сумын төсөвт 743.2 сая, нийт 10276.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

### **Гурав: Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Хууль зүйн сайдын эрхлэх хүрээний агентлагууд болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх, зүйн хэлтэсээс 2020 оны 04 дүгээр сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан хүүхэд хамгаалах багийн ажлын хэсэгт тус хэлтсийн 1 мэргэжилтэн 8 сум 1 тосгонд ажиллаж, сумдын хамтарсан багийн үйл ажиллагаатай танилцан зөрчил дутагдлыг арилгах цаашид ажлыг эрчимжүүлэх үүрэг даалгаврыг холбогдох сумдад өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын шийдвэртэй холбоотойгоор шүүхэд төлөөлөх эрхийн хүрээнд 1 маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр орж ажилласан байна.

Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд 4 дүгээр сард 4 сумын Засаг даргын 210 захирамжийн эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж чиглэл хүргүүлэн ажиллалаа. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн хангуулах үүднээс 16 сум, 1 тосгонд ажиллаж зүйн актыг гаргахад анхаарах, нийтийн эрх ашгийг хөндөхгүй байх, хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахад анхаарах асуудлаар зөвлөмж өгч ажиллалаа.

Дээд шатны байгууллагаас ирүүлсэн 4 албан бичгийн хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх зорилтын хүрээнд аймгийн Хууль зүйн туслалцааны төвөөр 12 иргэн үйлчлүүлж хуулийн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг авсан байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 4 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг танилцуулахад 145 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 хэргээр буюу 4,7 хувиар буурлаа. Илрүүлэлтийн хувь 35,5 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 21,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Бугат, Бүрэгхангай, Дашинчилэн, Сайхан, Сэлэнгэ, Хангал, Хялганат сумдад урьд оны мөн үеэс өсч, Баяннуур, Булган, Гурванбулаг, Орхон, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Рашаант сумдад урьд оны мөн үеэс буурсан байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тухайд 23 бүртгэгдэж 1 хэргээр буюу 4,6 хувиар өссөн.

### **Архивын тасгийн чиглэлээр:**

Лавлагаа авахыг хүссэн нийт 128 иргэнд /давхардсан тоогоор/ 733 баримтаар үйлчилсэн. Үүнээс тушаалын 311, цалингийн 395, малын А данс 27 баримт гаргасан. 98 иргэнд 233 хуулбарын лавлагаа олгож, 60 иргэнд цалингийн баримт, 25 иргэнд тодорхойлолт олгосон. Ажлын шаардлагаар 6 сард нийт 19 иргэнд 95 баримтаар үйлчилсэн.

### **Улсын бүртгэлийн чиглэлээр:**

#### **Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:**

Төрөлт-102, гэрлэлт-26, гэрлэлт цуцлалт-15, үрчлэлт-1, нас баралт-26, шинээр иргэний үнэмлэх-54, гадаад паспорт-7, лавлагаа-154-ийг олголоо.

#### **Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:**

Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл-28, Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт-1, Гэрээний эрхийн бүртгэл-258, Барьцааний гэрээ-73, Эд хөрөнгийн бүртгэлд шинээр бүртгүүлсэн хувийн сууц-13, Хувийн сууц бэлэглэх гэрээ-1, Шинээр бүртгүүлсэн орон сууц-0, Орон сууц бэлэглэх гэрээ-1 тус тус ажлыг гүйцэтгэлээ.

#### **Хуулийн этгээдийн бүртгэлийг чиглэлээр:**

Шинэ бүртгэл-3, нэмэлт өөрчлөлт-2, татан буугдсан-0, тамга тэмдэг-0, лавлагаа-7

### **Бүртгэл хяналтын чиглэлээр:**

Хяналт тавьсан бүртгэлийн тоо-54, Зөрчлийн шийдвэрлэлт-47, Иргэний бүртгэлийн чиглэлээр-24, ЭХЭБ-ийн чиглэлээр-35, Иргэний бичиг баримтын зөрчилтэй иргэдийн зөрчлийн хуулиар торгууль оногдуулсан-78

### **Дөрөв:Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

#### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

Шинэ коронавирусийн халдварын үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний нэмэлт төлөвлөгөө, Коронавируст халдвар /COVID-19/-ын үед ажиллах мэргэжлийн багийг байгуулах тухай тушаалыг шинэчлэн батлуулж ЭМБ-дад хүргүүлээ.

Аймгийн хэмжээний сонгуулийн 6 хэсгийн хороо болон 13 ухуулах байранд МУ-ын ЗГ-ын 188 дугаар тогтоол, ЭМГ-ын даргын А/59 тушаалаар хяналт, үнэлгээ хийн COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг цахимаар болон цаасаар хүргүүлэн, үнэлгээний дүн мэдээллийг ЭМЯ-нд хүргүүлсэн.

2020 оны 01 сарын 10-ны өдрөөс 06 сарын 12-ны өдрийг хүртэл гэрийн ажиглалтад байсан нийт 166 иргэний дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэн МХГ-т хүргүүлэн ажиллалаа.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 472 дугаар тушаалаар "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага"-аар Аймгийн Цагдаагийн газар, Булган сумын ЗДТГ, Булган сумын 4-р цэцэрлэг гэсэн байгууллагууд шалгарч 3-р зэргийн гэрчилгээ гардан авлаа. "Эрүүл ажлын байр"-аар Бугат сумын Эрүүл мэндийн төв, Тэшиг сумын Хилийн цэргийн 0286 дугаар анги, аймгийн Биеийн тамир, спортын газрын Усан спорт сургалтын төв зэрэг байгууллага шалгарч 3-р зэргийн гэрчилгээ гардан авлаа. "Эрүүл мэндийг дээдлэгч" өрхөөр Хялганат тосгоны иргэн Ж. Мөнхбат, Булган сумын иргэн Ш.Содном, Булган сумын иргэн Б.Мөнхбаатар нарын гэр бүлүүд шалгарлаа. "Эрүүл мэндийг дээдлэгч иргэн"-ээр Сайхан сумын иргэн М.Бат-Орших, "Бадрал сан"-гийн тэргүүн Б.Батбаяр, Сэлэнгэ сумын иргэн Т.Ууганбаяр нар шалгарлаа.

ЭМГ, АНЭ-тэй хамтран шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлын тохиолдолд суурилсан үзүүлэх дадлага сургуулилтыг зохион байгуулан ажиллалаа. Дадлага сургуулилтад нийт 33 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.

Эрүүл мэндийн яам, "Азийн хөгжлийн банк", "Глобал сан"-ийн хамтарсан "Вирус гепатит, сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, илрүүлгийг сайжруулах" нь төслөөс зохион байгуулсан "Сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, хяналтыг сайжруулахад эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах" сэдэвт сургалтад АНЭ, Сум өрхийн эрүүл мэндийн төвийн 60 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.

ЭМГ-ын төрийн албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсэг Рашаант сумын Эрүүл мэндийн төв, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, эрүүл мэндийн салбарын харилцааг зохицуулж буй хууль, тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

#### **Нийгмийн халамжийн чиглэлээр:**

#### **Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр**

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 2020 оны 6-р сарын байдлаар 952 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаагаас шинээр 149 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгүүлсэн байна. Бүртгэлтэй ажилгүй иргэд бага буюу боловсролгүй иргэд

16 хувь, бүрэн дунд боловсролтой 63,7 хувь, дипломын болон бакалаврын дээд боловсролтой 10,9 хувь, тусгай болон техникийн мэргэжилтэй иргэд 9.4 хувийг эзэлж байна. Нийт иргэдийн 82 хувь нь 25-54 насныхан байна.

Ажил олгогч 74 байгууллагаас 86 ажлын байрны захиалга авч, орон нутгийн телевиз болон зарын цэгүүдээр байршуулан зар сурталчилгааг явуулж ажиллалаа.

Шинэ ажлын байр: Шинээр бий болж байгаа ажлын байранд 160 иргэн орж ажилласнаас байнгын ажлын байранд 30 иргэн, улирлын ажлын байранд 23 иргэн, түр ажлын байранд 107 иргэн тус тус ажлын байранд зуучлагдан ажиллаж байна.

Ажилд зуучлагдсан иргэн: Ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын сул чөлөөтэй ажлын байранд 163 иргэн ажлын байранд зуучлагдсанаас байнгын ажлын байранд 28 иргэн, улирлын ажлын байранд 47 иргэн, түр ажлын байранд 88 иргэн зуучлагдан ажиллаж байна.

Нийт сумдад хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг шинэчлэн байгуулах ажлын хүрээнд сумдын мэргэжилтэнд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан бөгөөд 6-р сарын байдлаар 14 сумд хэлэлцээрээ байгуулан ирүүлээ. Сумдын хэлэлцээрийн хагас жилийн биелэлтийг тооцон ажиллаж байна. 2 суманд ажил олгогч эздийн холбоо байгуулагдаагүйгээс хэлэлцээр удаашралтай байна.

Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээг 16 сум 1 тосгонд зохион байгуулахаар 41 төслийг 92,8 төгрөгөөр дэмжин 549 иргэнийг түр ажлын байраар хангахаар төлөвлөн ажиллаж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 24 иргэнийг 50 сая төгрөгөөр, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 20 ахмадын төслийг 30 сая төгрөгөөр, дэмжин гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой иргэдийн хүсэлт, Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан 132 иргэнд бизнесээ эхлэх, өргөжүүлэхэд нь зориулан “Бизнесээ эхэл”, “Бизнесээ хөгжүүл” аж ахуй эрхлэлтийн сургалтыг “Хөгжлийн хөтөч” ОЗХ сургалтын төвтэй хамтран онлайн-аар зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн төслүүдийг газрын даргын тушаалаар байгуулагдсан төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн хурлаар шийдвэрлэлээ. Хөгжлийн бэрхшээлтэй 24 иргэнд 50,0 сая, АМЗҮХСД-т 20 иргэнд 30,0 сая, АБДХөтөлбөрт 19 иргэнд 68,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 11 хүнд 68,5 сая, Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах 6 бүлгийн 40 хүнд 19,7 сая, Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 5 хүнд 4,3 сая, Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн Нийтийг хамарсан ажилд 292 хүнд 51,7 сая, Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн борлуулалтын дэмжлэг, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт 3,0 сая, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 24 хүнд 50,0 сая, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр дэмжих хөтөлбөрийн ажил олгогчийн урамшуулалд 2 аж ахуй нэгжид 5,7 сая, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 20 хүнд 30,0 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Нийгмийн халамжийн чиглэлээр:**

Халамжийн сангаас 2020 оны 6-р сард 8321 иргэнд 791,2 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт олгогдсон. Бүх сумдаас тэтгэвэр тэтгэмжийн хувийн хэрэг, нэг удаагийн хөнгөлөлтийн материалыг хүлээн авч хянан олголтыг хийсэн. Мөн УБГ-аас нас барсан иргэдийн жагсаалтыг авч 45 иргэнийг WAIS програмд тулгалт хийн, 9 иргэний үйлчилгээг зогсоов. ХХҮЕГ-аас нас барсан иргэдийн тулгалтыг долоо хоног бүр хийж, үйлчилгээг зогсоож байгаа бөгөөд 9 асрагчийн үйлчилгээг зогсоож, халамжийн сангийн олголтын талаар мэдээлэл авахаар биечлэн ирж уулзсан 13, утсаар холбогдсон 14 иргэний асуудалд хариу өгч шийдвэрлэсэн.

Насны хишигт шинээр орж байгаа болон 70, 80, 90 нас хүрч шифр дэвшиж байгаа иргэдийн үйлчилгээг шалгаж баталгаажуулсан. Насны хишиг хувь олголтыг 3201 ахмадад 263,2 сая төгрөгийг 06-р сарын 18-наас олгож эхэллээ.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 875 өрхийн 2371 том хүн, 2190 хүүхэд хамрагдаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/13 дугаар тушаалаар хүнсний эрхийн бичгийн босго оноо аймагт 310,0 оноо болж шинэчлэгдсэний дагуу сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн шийдвэрийг үндэслэн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд Хялганат тосгоны 1 өрх, Булган сумын 2 өрх, нийт 3 өрхийн 13 том хүн, 9 хүүхдийг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд шинээр хамрууллаа.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний гэрээний дагуу ажил гүйцэтгэж байгаа “Оргил мээж холбоо” ТББ-н ажлын гүйцэтгэл, хувийн хэрэгт хяналт хийж санхүүжилтийг олгосон. Мөн “Тунгалаг аялгуу” ХХК-ийн баримтад хяналт хийлээ.

Шинэ төрсөн 425 хүүхдийг ӨМНС-д бүртгэж, үүнээс 26 хүүхдийг бусад аймаг, дүүрэгтэй холбогдож бүртгүүлж, үрчилсэн 1, овог, нэр өөрчлөгдсөн 18, ӨМНС-д бүртгэлгүй 81 хүүхдийн мэдээллийг шинээр оруулсан.

Үзүүлэлт	Хүний тоо	Өртөг /мян.төг/
Халамжийн тэтгэвэр	1085	1012340.1
Халамжийн тэтгэмж	2526	599418,3
Ахмад настанг асарч буй иргэнд НМТ	909	358677,6
ХБ-тэй иргэнийг асарч буй иргэнд НМТ	330	126389,9
Байнгын асаргаатай ХБ-тэй хүүхэд НМТ	189	105123,3
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсөн тэтгэмж	25	9227,5
Ахмад настанд үзүүлсэн тусламж/хөнгөлөлт	865	69863,0
ХБ-тэй иргэнд үзүүлсэн тусламж/хөнгөлөлт	146	29691,5
Амьжиргаа дэмжих сангаас олгосон/тусламж	1309	302164,3
Алдарт эхийн одон	5492	702500,0
Хүнс тэжээл хөтөлбөр	4549	242848,0
Алдар цолтой ахмад	29	23000,0
Цалинтай ээж	668	128739,0

### **Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:**

Шинэ төрлийн корона вирусийн тархалтаас сэргийлэн олон нийтийг хамруулсан үйл ажиллагааг хориглосон тул байгууллагын төлөвлөгөөт арга хэмжээнүүд хойшлогдсон байна.

Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан Аз жаргалтай гэр бүл-3 15 хоногийн аяны хүрээнд байгууллагын эцэг эхийн зөвлөлүүдийн дунд уралдаан зохион байгуулсан. Эцэг эхийн зөвлөлүүд байгууллагын албан хаагчдад Гэр бүлийн үнэ цэнийг таниулах, угийн бичгийн сургалтыг зохион байгуулсан тайлангаа манай байгууллагад ирүүлсэн. Шилдэг эцэг эхийн зөвлөлөөр Онцгой байдлын газрын эцэг эхийн зөвлөл шалгарсан байна.

Хүүхэд хүмүүжлийн эерэг арга цахим сургалтын 3 дугаарыг байгууллагын цахим хуудсаар олон нийтэд хүргэсэн.

Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан болж хүүхэд хамгаалалд тулгамдаж буй асуудлаар гишүүн байгууллагууд хэлэлцлээ.

Аймгийн хүүхдийн парламентийн хүүхдүүд хойд бүсийн Тэшиг, Хутаг-Өндөр сумдад туршлага солилцох аялалыг зохион байгууллаа.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:**

#### **Мал аж ахуйн талаар:**

Хишиг-Өндөр, Могод, Гурванбулаг, Дашинчилэн, Баяннуур, Рашаант сумдын ихэнх нутгаар, Баян-Агт, Сайхан, Орхон, Бүрэгхангай, Сэлэнгэ сумын зарим багийн нутгаар даац 1-3 дахин, Орхон, Хишиг-Өндөр, Рашаант сумдын нутгаар даац 3-5 дахин хэтэрсний дээр бэлчээрийн ургац тааруу, зарим сумдад үлийн цагаан оготно ихээр тархсан, отор нүүдэл их учраас хаваржилт хүндэрч, малын хорогдол их гарсан.

Аймгийн хэмжээнд 3.6 сая толгой мал хаваржиж байгаагаас тэмээ 1452, адуу 272.0 мянга, үхэр 282.3 мянга, хонь 1923.8 мянга, ямаа 1162.0 мянга байна.

Нийт 1651.3 мянган хээлтэгч төллөнө. Өнөөдрийн байдлаар нийт төллөх малын 73,7 хувь буюу 1216713 хээлтэгч төллөж, төрлөөр нь авч үзвэл ингэ 166, гүү 54508, үнээ 73969, эм хонь 714146, эм ямаа 373925 тус тус төллөж, төл бойжилт 93,4 хувьтай байна.

Өнөөдрийн байдлаар 122299 толгой мал хорогдсон бөгөөд адуу 9532, үхэр 8784, хонь 73433, ямаа 30550 толгой тус тус хорогдсон байна. Үүнээс 1286 толгой мал өвчнөөр хорогдсоны адуу 93, үхэр 150, хонь 665, ямаа 378 тус тус хорогдсон. Хамгийн их хорогдолтой сум Сайхан /46686/, Баян-Агт /38015/, Могод /8808/ байна. Хээлтүүлэгч мал Баян-Агт суманд хуц 215, ухна 143 хорогдсон байна. Аймгийн нийт малын 2.47 хувь нь хорогдсон мэдээ байна.

Улсын төсвийн хөрөнгөөр бэлчээрийн хөнөөлт мэрэгчидтэй микробиологийн аргаар Рашаант, Гурванбулаг сумдын бэлчээрийн 37.5 мянган га-д, энгийн механик аргаар Дашинчилэн, Баяннуур, Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумдын бэлчээрийн 70.0 мянган га-д, орон нутгийн төсвийн хөрөнгөөр энгийн механикийн аргаар Могод, Орхон, Сайхан сумдын бэлчээрийн 40.0 мянган га, нийт 147.5 мянган га-д тэмцэх арга хэмжээг 04 дүгээр сарын 01-нээс 5 дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаанд зохион байгууллаа.

УИХ-ын 2020 оны 32-р тогтоол, Засгийн газрын 167-р тогтоолын дагуу 9427 малчин өрхийн 1,1 сая ямааны ноолуурын урамшуулал 6,6 тэрбум төгрөгийн урамшууллын мөнгийг малчны дансанд оруулах ажлыг гүйцэтгэлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр гаргах инженерийн хийцтэй 2 худгийн хяналтын гэрээг төслийн удирдлагын нэгжтэй байгуулав, Мөн орон нутгийн төсвийн

хөрөнгө 510,0 сая төгрөгийн 30 инженерийн хийцтэй худаг шинээр гаргах тендер 4-н багцаар зарлагдаж, “Булган-Ус” ХХК, “Таширын хүрээ” ХХК, “БИММ” ХХК-ууд шалгарч, гэрээ байгуулан ажлаа эхлээд байна.

#### **Үйлдвэр, худалдаа үйлчилгээний талаар:**

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 1,313,293.4 мянган төгрөгийн зээл авсан 22 төслийн эргэн төлөлт хэвийн төлөгдөж, 22.9 хувьтай байна.

2020 оны 4 сарын 20 ны өдрөөс эхлэн 5 дугаар сарын 19-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл 1 сарын хугацаанд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээл нэгэн зэрэг зарлагдсан. Энэ хугацаанд аймгийн хэмжээнд 12 сумын 2,929,845.6 мянган төгрөгийн 33 төслийг хүлээн авч, журмын дагуу ХХААГ-ын даргын 2020 оны А/07 тоот тушаал бичиг баримт, иж бүрдэл шалгах ажлын хэсгийг томилсон. Ажлын хэсэг журмын 1.4 дэх заалтын дагуу шалгахад 428,570.0 мянган төгрөгийн 6 төсөл хасагдаж, 5.9 дэх заалтын дагуу шалгахад 446,500.0 мянган төгрөгийн 4 төсөл хасагдаж, мэдээллийг программд скайнердан орууллаа. Тэнцсэн 2,054,775.6 мянган төгрөгийн 23 төслийг урьдчилсан хяналт хийх шат руу шилжүүлэн ажиллаж байна.

ХХААХҮЯ-ны Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооноос хамтран улсын хэмжээнд бүртгэлтэй байгаа хоршоодод үнэлгээ хийх ажлыг 16 сум 1 тосгоны үйлдвэр, үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүдэд “Хоршооны хөгжлийн үнэлгээний арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. 16 сум 1 тосгоны ҮХҮХ мэргэжилтнүүд улсын бүртгэлд байгаа хоршоодад хөгжлийн үнэлгээ хийж байна.

“Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран Бугат, Баяннуур, Дашинчилэн, Орхон сумдад сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдах хүсэлтэй бизнес 80 гаруй бизнес эрхлэгч иргэдэд төслийн анхан шатны сургалт мөн зээлийн батлан даалтын сангийн мэдээлэл танилцуулан ажиллаа.

#### **Мал эмнэлгийн чиглэлээр:**

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ: Нийт 1,255 мян.тол мал хамрагдахаас 663,2 мян.тол мал хамрагдаж 52,8 хувийн гүйцэтгэлтэй байна МЭЕГ-ын даргын А/108 тушаал, аймгийн Засаг даргын А/219 захирамжийн дагуу Баян-Агт, Могод, Сайхан сумдын нийт 617,9 мал сүргийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээнд хамруулж 99,8 хувийн гүйцэтгэлтэй вакцинжуулалтын арга хэмжээ дууссан ба гүйцэтгэлийг Газрын даргын зөвлөлийн хурлаар танилцуулсан. Малын хорогдолтой холбоотой үлдэгдэл 96,1 м/т шүлхий вакциныг “Биокомбинат” УТҮГ-ын вакцин хүргэлтийн хөргүүртэй машинаар МЭЕГ-т буцаасан.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэл 8 сумын 20 МЭҮН-ээс ирснээс Рашаант сумын 2 мал эмнэлэгт 14,8 сая төгрөгийн үйлчилгээний хөлс шилжүүлсэн. Бусад мал эмнэлгийн гүйцэтгэлийг шалгаж байна.

Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээ: Туулгалтын арга хэмжээнд 972.4 мянган толгой мал, 1.2 нохой нийт 973,6 мянган мал амьтан, хачиг ширхний боловсруулалтад 552,1 мянган мал, гуурын боловсруулалтад 222,1 мянган үхэр, угаалгын арга хэмжээнд 62,3 мянган мал нийт 1,810 мянган толгой мал амьтан хамрагдсан.

Ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээ: Монгол улсын Ерөнхий сайдын 01 тоот албан тоот даалгавар, аймгийн Засаг даргын А/154 тоот захирамжийн дагуу аймгийн хэмжээнд 86823 мянган мал амьтны сэг зэм устгаж, 74,1 хувийн гүйцэтгэлтэй. Нийт 332,9 мян.м<sup>2</sup> талбай халдваргүйжүүлэхээс 1507,9 мян.м<sup>2</sup> халдваргүйжүүлсэн байна.



Мал эмнэлгийн цахим бүртгэл, гэрчилгээний талаар: Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн нарт энэ онд хэрэгжүүлэх халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хийгдэх төлөвлөгөөт арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийг мөн малд эрүүл мэндийн үзлэг хийх, малчдад зөвлөмж өгсөн ажлыг цахим бүртгэлд шивж оруулах талаар зөвлөж, арга хэжээг хэрэгжүүлж эхэлсэн. Нийт сумдад 3874 толгой амьд мал, 42289 кг мах, 470 литр сүү тарга, 3179 кг ноолуурат тус тус үзлэг хийж, нийт 380 ширхэг мал эмнэлгийн гэрчилгээ олгогдсон байна.

Мал эмнэлгийн нийт 175 дуудлагад малын эмч нар явж үйлчилсэн. Ихэвчлэн мал төлөлттэй холбоотой мал хээл хаях, хаг саатах, сав урвах зэрэг мөн шимэгчтэх, эндемик, төл малын өвчний дуудлага ирж байна.

Нян судлалын шинжилгээ: Баян-Агт, Тэшиг, Сайхан, Баяннуур, Хишиг-Өндөр, Орхон сумдаас 18 дээж ирсэн. Баян-Агт сумын Баянзүрх багийн малчин Л.Баярсайханы хонинд энтербактер оношлогдсон. Орхон, Тэшиг сумаас ирүүлсэн дээжид шинжилгээ хийгдэж байна. Сайхан сумаас ирүүлсэн дээж чанарын шаардлага хангаагүй учраас шинжилгээнд тэнцээгүй.

Ийлдэс судлалын шинжилгээ: Хангал, Баян-Агт, Булган, Орхон сумаас нийт 209 дээж ирүүлсэн. Листериоз өвчний шинжилгээнд 101 малаас цусны дээж ирүүлснийг ийлдсийг ялган - 20□ С-д хадгалж байгаад шинжилгээг хийж эхлээд байна. Бруцеллэз өвчний шинжилгээнд Булган, Орхон сумын 100 бухын ийлдсэнд эзонт урвалаар шинжилгээг хийж гүйцэтгэхэд эсрэг биет илрээгүй сөрөг дүн үзүүлсэн. Нийлүүлгийн өвчний шинжилгээнд адууны 9 ийлдсийг нийлүүлгийн өвчний тестээр шинжилгээг хийж гүйцэтгэхэд эсрэг биет илрээгүй сөрөг урвал үзүүлсэн.

### **Зургаа: Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын чиглэлээр:**

#### **Байгаль орчны чиглэлээр:**

Бугат, Сэлэнгэ, Хангал сумдад хийгдэж байгаа ойжуулалтын ажилд сум, сум дундын ойн анги газрыг зааж өгөн хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 13943 ширхэг мод бутыг тарьж 2500м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлэх талбайг бэлтгэж, 276,3 м<sup>2</sup> талбайн цэцгийн мандлыг бэлтгэн ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Могод сумын Засаг даргын Тамгын газрын хог хаягдлын нэгдсэн цэгийн төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Бүрэгхангай сумын уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч 11 аж ахуйн нэгж, 3 нөхөрлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Бугат, Рашаант, Сэлэнгэ, Хангал сумдад хийгдэж байгаа ойжуулалтын ажилд сум, сум дундын ойн ангитай хамтран тарилтын стандарт, шон тэмдэг, тэмдэглэгээг тавьсан байдал зэргийг хянан үзэж заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Бугат, Рашаант суманд хийгдэж байгаа ойжуулалт ойн зурвас ажлын тарилтын үеийн хяналтыг хийсэн.

Сэлэнгэ, Хангал сумдад “Гранд форест” ХХК, “Залуу төгөл” ХХК ойн хортны тэмцлийн ажлын үүргийн шүршигч, агаарын хөлгөөр 8000 га талбайд хийж байгаа ажилд сум дундын ойн ангитай хамтран хяналт тавьж ажиллалаа.

Ойн хортны судалгааны ажил болон онгоц, үүргийн шүршигчээр тэмцлийн ажлын гүйцэтгэлийн хяналтыг нисдэг камераар зураг авалт хийсэн.

“Хоггүй цэвэрхэн Монгол” аяны хүрээнд 05-р сард хийсэн ажлын тайлан, мөн аяны хүрээнд 2019 оны 08-р сараас 2020 оны 05-р сард зохион байгуулсан ажлын тайланг нэгтгэн гаргаж БОАЖЯ-нд хүргүүлсэн.

Улаанбаатар хотын “Эко тайхи” ХХК-ийн захирал, инженертэй уулзан Мал эмнэлгийн лаборатори, Дөлгөөн салон орчмын химийн бодисоор бохирдсон газрыг цэвэрлэх талаар санал солилцон, тухайн газрын байдлыг танилцуулсан.

### **Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:**

2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д 2568 арга хэмжээг оруулан Булган аймгийн цахим систем болон “Булган Сайхан монгол” телевизээр сурталчлан ажиллалаа. 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр тооцоход Хот тосгон бусад суурин газрын төлөвлөлт хуучин эзэмшиж байгаа хашааны газрыг 6 иргэнд 0,65 га газрыг өмчлүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ, ХАА-н бирж, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мод, таримал ургамал тариалах зориулалтаар 38 нэгж талбарын 236,3 га газрыг газрын биржээр зарлаж, 25 нэгж талбарын 216,02 га газрыг дуудлага худалдаагаар, төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд 3 нэгж талбарын 4 га, төсөл сонгон шалгаруулах журмаар 1 нэгж талбарын 3 га, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 83 иргэнд 4,77 га, үр тарианы зориулалтаар давуу эрхээр 100 га газрыг эзэмшүүлж төлөвлөгөөний биелэлт 22% хувьтай. ХАА-н газрын төлөвлөлт 83 иргэнд 30.32 га газрыг өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшүүлсэн. 4, 5 дугаар сард Булган аймгийн хэмжээнд 83200 га бэлчээрт оготно устгалын ажлыг зохион байгуулсан.

### **Газрын төлбөр, үнэлгээний чиглэлээр:**

Газрын төлбөрийн нэхэмжлэлийг аймгийн хэмжээнд үүсгэн 2020 оны 01/616 дугаар албан бичгээр Татварын хэлтэст хүргүүлсэн. 2020 оны 06-р сарын 11-ны байдлаар 14280 нэгж талбараас 10064 нэгж талбарын газарт нэхэмжлэлийг үүсгээд байгаа ба үүсгэгдээгүй нэгж талбарын газрууд нь татвар төлөгчийн дугаар бүртгэлгүй, хөрөнгийн бүртгэл үүсэхгүй гэсэн алдаанууд гарч байгаа тул ТЕГ, ГЗБГЗЗГ-ын холбогдох мэргэжилтнүүдэд нь алдааг засварлах арга хэмжээг авч ажиллаж байна. Аймгийн хэмжээнд газрын төлбөрт нийт 145,6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс аймгийн төрийн сангийн 100040000943 тоот дансанд 2020 оны 06-р сарын 22-ны байдлаар 200,0 сая төгрөг төвлөрөөд байгаа ба биелэлт 137 %-тай байна.

Газрын дуудлага худалдаа, орлогын талаар:

2020 оны хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд газрын дуудлага худалдаанд 7,3 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгдсөн. Газрын бирж буюу me.mn вэб сайтад 6-р сарын 09-ны байдлаар Орхон сум 10 нэгж талбар, Бугат сум 1 нэгж талбарт, Булган сум 10 нэгж талбарт, Баян-агт сум үйлчилгээний зориулалтаар 1 нэгж талбарын газруудыг дуудлага худалдаагаар олгохоор тус тус зарласны дагуу Баян-Агт сум 100м<sup>2</sup> газрыг 3,0 сая.төгрөг, Бугат суманд үр тарианы зориулалтаар 200 га газрыг 18,1сая төгрөг, Сэлэнгэ суманд үйлчилгээний зориулалтаар 500м<sup>2</sup> газар 1,15 сая төгрөг, Булган сум хүнсний ногоо болон ШТС-ын зориулалтаар 10 нэгж талбар бүхий газарт 41,0 сая төгрөг, Орхон суманд 10 нэгж талбарт 15,0 сая төгрөг, аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий төлөвлөгдсөн газарт орон сууц болон авто гараашны зориулалтаар 5 нэгж талбарын газарт 920 м<sup>2</sup> газрыг 41,07сая төгрөгөөр, аймгийн хэмжээнд нийт 30 нэгж талбараас 119,3 сая төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлээд байна.

### **Тэмдэгтийн хураамжийн орлогын талаар:**

Тэмдэгтийн хураамж, хураамжийн ногдуулалтыг хийж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх явц нь ГЗБГЗЗГ болон ТЕГ-ын дундын мэдээллийн сангаар үүсгэгдэж байгаа ба энэ нь одоогоор төлбөрийн даалгавар үүсэх нөхцөл нь алдаатай. Itax.mta.mn-д тэмдэгтийн хураамжийг үүсгэн орон нутгийн дансанд төвлөрүүлээд байна. Үүнд: 2020 онд шинээр 386 газар эзэмших гэрчилгээ олгож 2566,0 мянган төгрөгийг, газар эзэмших эрх шилжүүлсэн нийт 179 иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 2017,3 мянган төгрөгийг, газар эзэмших гэрээний хугацаа дуус ч шинээр гэрчилгээ авсан 152 иргэд аж ахуйн нэгж байгууллагаас 1090,0 мянган төгрөг нийт 6553.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.

### **Геодиз, зураг зүйн чиглэлээр:**

Хишиг-Өндөр сумын Засаг даргын тамгын газраас ирүүлсэн 2020 оны 01/115 тоот албан хүсэлтийн дагуу тус суманд 2020 оны 06-р сарын 16-ны өдөр ажилласан. Тус суманд ажиллах явцад 2017-2018 онд 84 иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн газрын байршлыг сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн газар дээр эргэлтийн цэгийг тэмдэгжүүлээ.

“Булган аймгийн газар нутгийг илэрхийлсэн самбар хийж, хил орчмын бүсүүдэд байршуулах ажил”-ын гүйцэтгэгч “Дижитал мэппинг” ХХК ажлын явцад техник хяналтыг 2020 оны 06-р сарын 08-ны өдөр хийж гүйцэтгэсэн. Үзлэг, хяналтаар гүйцэтгэгч байгууллагатай хаягийн самбар, баганын байршлыг газар дээр шалгаж тодруулав.

Дээрх ажлыг гүйцэтгэгч байгууллага гэрээнд заасан хугацаанд бүрэн хийж гүйцэтгэн актаар хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Газрын кадастрын хэмжилтийг нийт 13 нэгж талбар, үл хөдлөх эд хөрөнгөнд хийж гүйцэтгэснээс 5 иргэн, хуулийн этгээд газар болон үл хөдлөх эд хөрөнгийн зураглалыг мэдээллийн санд оруулж ажилласан. Дээрх үйл ажиллагаанаас 118480 төгрөгийг төрийн сангийн 100040029002 дансанд төвлөрүүлэв.

### **Суурь судалгаа, газрын мониторингийн чиглэлээр:**

Парисын хэлэлцээрийн хүрээнд МУ-ын оруулах Үндэсний хувь нэмрийн (NDC) хэрэгжилтийг хөдөө аж ахуй, газар ашиглалтын салбарт илт тод байдлаар тайлагнах, мониторингийн үндэсний чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд аймгийн хэмжээнд нийт 4918 цэгт газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээг хийх болсонтой холбогдуулан төлөвлөгөө гарган нийт 1630 цэгийн үнэлгээг програмд оруулан ажиллалаа.

Дашинчилэн, Могод, Орхон, Хишиг-Өндөр сумын бэлчээр ашиглалтын хэсгийг Газрын мэдээллийн санд оруулахаар мэдээллийг ГЗБГЗЗГ-ын суурь судалгаа, мониторингийн хэлтэст хүргүүлээ.

### **Газрын кадастрын чиглэлээр:**

ГЗБГЗЗГ-ын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын шинэчлэн боловсруулсан журмын төсөлд 2020 оны 01/652 албан бичгээр санал өгсөн.

Нийслэлийн ШШГГ, Орхон аймаг дахь ШШГГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу тус тус иргэн, хуулийн этгээдийн өмчилж, эзэмшиж буй газрын зөрчил, маргаантай холбоотой лавлагаа, нотлох баримт, мэдээллийг хугацаанд нь гарган хүргүүлээ.

Газар эзэмшүүлэх дуудлага худалдаанд оролцож ялагч болсон 4 иргэнд аймгийн Засаг даргын 2020 оны А/273 дугаар захирамжаар газар эзэмшүүллээ. Үүнд: Авто гараашийн газрын зориулалтаар газар эзэмших эрх авсан 3 иргэн, орон сууцны газрын зориулалтаар газар эзэмших эрх авсан 1 иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олголоо.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/280 дугаар захирамжаар Булган сумын 6 дугаар баг Залуус 1 дүгээр гудамж 104 дүгээр байрны баруун талд явагдсан газар эзэмшүүлэх дуудлага худалдаанаас хүчингүй болсон 2 нэгж талбарт авто машины гараашийн зориулалтаар газар эзэмшүүлэх дуудлага худалдааг 2020 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 9:00 цагт дахин явуулахаар товлоод байна.

Газар эзэмших эрх шилжүүлэхийг хүссэн 10 өргөдөл ирүүлснээс аймгийн Засаг даргын 2020 оны А/261, А/275 дугаар захирамжаар 4 иргэн, 1 төрийн байгууллагын газар эзэмших эрхийг шилжүүллээ.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/270, А/271 дүгээр захирамжаар газрын хэмжээнд өөрчлөлт орсон 1 иргэн, 2 хуулийн этгээдийн газар эзэмших гэрээ, гэрчилгээг шинэчлэн олголоо.

2020 оны А/263 дугаар захирамжаар үйлчилгээний зориулалтаар газар эзэмшиж буй 2 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 5 жилээр сунгалаа. Газар эзэмших эрхийн Э дугаар авахтай холбоотой 10 өргөдөл, хүсэлт ирүүлснийг шийдвэрлэн гэрээ, гэрчилгээг шинэчлэн олгов.

Газар эзэмших эрх шилжүүлэх 5 иргэн, 1 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах, 1 иргэнд амины орон сууцны зориулалтаар шинээр газар эзэмшүүлэх захирамжийн төслүүдийг 2020 оны 01/675 албан бичгээр аймгийн Засаг даргад хүргүүллээ.